

PLITONIT

МЭРГЭЖИЛТЭН БАЙХ АМАРХАН



PLITONIT S10 – механик болон гар аргаар хэрэглэх цементэн шавардлага өнгөлгөө



Энэхүү бүтээгдэхүүн нь бетон, тоосго, хийт бетоноор хийсэн ханыг механик болон гар аргаар тэгшлэх, түүнчлэн хуурай, чийгтэй өрөөнд, болон гадна талын фасадны шавардлага өнгөлгөөнд бетон ба төмөр бетон хавтангийн залгаас, зарим тэгш бус байдлыг засах зориулалттай. Нийтийн эзэмшлийн талбай, орон сууц, тэр дундаа сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууламж (эмчилгээ, урьдчилан сэргийлэх, амралт-сувиллын байгууламжууд)-д хэрэглэж болно. Нэг удаагийн түрхэх давхаргын зузаан 5-50 мм байна. Дүүргэгчийн хамгийн том ширхгийн хэмжээ: 2,5 мм.

Савлагаа — 25 кг

- дотор болон гадна талын ажилд зориулагдсан
- хагарал цууралтад тэсвэртэй, чийгт тэсвэртэй
- механик болон гар аргаар түрхэхэд тохиромжтой

Бүтээгдэхүүний зарцуулалт

1 мм зузаантай түрхэх үед 1,25-1,35 кг/м².

Ажлын нөхцөл

Ажлын явц болон гүйцэтгэлээс хойших 3 хоногт агаарын температур, суурийн болон хавтангийн температур +5 °C хэмээс +30 °C хэмийн хооронд байх нь зохимжтой. Ажлын явцад зуурмагийн температур +10°C хэмээс +30°C хэм хүртэл байх нь зохимжтой. Гаднах ажлын гүйцэтгэлийн үед хур тунадаснаас хамгаалах шаардлагатай.

Гадаргууг бэлтгэх

Өнгөлгөөний доорх гадаргуу нь бат бэх байх шаардлагатай, ажил эхлэхээс өмнө гадаргууг тоос, шороо, тос, бүх төрлийн будаг болон цавуу, хуурах боломжтой элементүүдээс сайтар цэвэрлэх шаардлагатай. Гөлтгөнө суурин гадаргуу болон ус шингээх чадвар өндөртэй гадаргууг өнгөлөхдөө үйлдвэрлэгчийн зааврын дагуу ажил эхлэхийн өмнө PLITONIT хөрсжүүлэгчээр бүрсэн байх шаардлагатай. Цаашдын ажлыг хөрсжүүлэгч бүрэн хатсаны дараа гүйцэтгэнэ.

Ажлын дараалал

Шавардлага өнгөлгөөний станцыг ашиглалтын зааврын дагуу ажилд бэлтгэнэ. Шавардлага өнгөлгөөний станцын зуурмагийн хоолойг усаар урсгаж норгоно. Хуурай хольцыг хүлээн авах бункерт хийнэ, зуурмагийн хольцын хүссэн найрлагаас хамааран усны хангамжийг тохируулна. Зуурмагийг шүрших хэлбэр, өргөнийг (дөл) тохируулна. Зуурмагийн бууг хананд перпендикуляр, түүнээс 30 см зайд барих ёстой. Зуурмагийн хольцыг хэвтээ судлуудаар түрхэж, дээрээс нь доошоо буулгаж, дараагийн судал бүр нь өмнөхтэй нь давхцаж байхаар, үүний тулд шинэ судлын шүрших төв нь өмнөхийн доод ирмэг дээр байх ёстой.

Зуурмагийн бууг хөдөлгөх хурдаар хэрэглээний давхаргын зузааныг тохируулна - энэ нь бага байх тусам давхарга зузаан болно. Зуурмагийн хольцыг хэрэглэсний дараа зуурмагийн буу дээрх агаарын хавхлагыг хааж, зуурмагийн хоолойг угаах шаардлагатай.

Гар аргаар түрхэх

Зуурмагийг бэлтгэхийн тулд энгийн ундны усыг ашиглана. Холих харьцаа: 25 кг хуурай өрлөгийн хольцод 4,25-5,5 литр ус шаардагдана. Хуурай хольцыг тасалгааны температурт урьдчилан хэмжсэн зохих хэмжээний ус руу хийнэ, нэгэн төрлийн жигд болтол нь 2-3 минутын турш цахилгаан холигч эсвэл цахилгаан өрмийн тусламжтайгаар холино (эргэлтийн хурд нь 600 эрг/мин-ээс ихгүй байна). Зуурмагийг ойролцоогоор 5 минут амраан дахин холино. Энэ үед зөвшөөрөгдсөн хамгийн дээд хэмжээний үлдсэн усыг нэмж хэрэглэж болно. Бэлэн зуурмагийг хэрэглэх хугацаа нь 4 хүртэлх цаг байх бөгөөд агаарын хэт халалт болон нэвт салхи энэ хугацааг багасгахад нөлөөлнө. Өнгөлгөө шавардлагын зуурмагийг гадаргуу дээр гурвалжин хусуураар шидэж эсвэл ган хусуураар түрхэж, үрэгч болон хусуураар тэгшилнэ.

Анхааруулга

Шавардлагын ажлыг гүйцэтгэхдээ Дүрмийн нэгтгэл 71.13330.2017 "Тусгаарлагч ба өнгөлгөөний шавардлага" -ийн шаардлагыг дагаж мөрдөх ёстой. Хэрэв гадаргуу хэтэрхий хурдан хатаж байвал эхний хоногийн турш чийгшүүлнэ. Залгаас нь аль болох бага ажиглагдах газарт байрлах ёстой. Ажлын үед завсарлага хийх тохиолдолд дуусаагүй шавардлагын гадаргууг хурц ирмэгээр (наалдамхай тууз ашиглан) дуусгах хэрэгтэй. Барилгын фасадыг шавардлагын үед найдвартай наалдамхай байдлыг хангахын тулд торыг (20х20 эсвэл 40х40 мм хэмжээтэй) татаж өгдөг. Өнгөлгөөний шавардлагын давхаргыг хэрэглэх үед унжуулахгүйн тулд торыг 30 см-ийн шатрын алхамтай шаталсан хэв маягаар хананд боолтоор бэхэлж өгнө. Ажил гүйцэтгэх явцад зуурмагийг үе үе хольж байх ёстой. Бэлэн болсон хольц дээр нэмэлт ус нэмж хийхийг хориглоно. Дээр заагдсан шинж чанарууд нь орчны температур (20±2)°C, агаарын харьцангуй чийгшил (60±10)%-д үйлчилнэ.

Аюулгүй ажиллагаа

Хольц нь ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 12.1.007 стандартын дагуу аюулын 4-р (бага аюултай бодис) ангилалд хамаарна. Ажил гүйцэтгэхдээ бээлий, нүдний шил, амны хаалт хэрэглээрэй. Зуурмагийг арьс, нүдэнд хүрэхээс зайлсхийх. Нүдэнд хүргэсэн тохиолдолд нэн даруй их хэмжээний усаар зайлна. ХҮҮХДЭЭС ХОЛ БАЙЛГААРАЙ.

Тээвэрлэлт болон хадгалах нөхцөл

Хуурай хольцыг ачаа тээвэрлэх дүрмийн дагуу бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Хуурай хольцтой уутыг савлагааны аюулгүй байдал, чийгээс хамгаалсан хуурай өрөөнд хадгална. Бүтээгдэхүүний хадгалах хугацаа нь үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар байна.

Орц, найрлага

Элс, портландцемент, эрдэс дүүргэгч, бэхжүүлэгч утас, өөрчлөгч нэмэлт бүтээгдэхүүнүүд.

Үйлдвэрлэгчийн баталгаа

Хэрэглэгч энэ зааврын тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл, зааврыг дагаж мөрдсөн тохиолдолд хольц нь ОХУ-ын стандарт хэмжилзүйн ГОСТ Р 33083 стандарт, С2 Е S2 ангилал болон 23.64.10-151-515521552022 техникийн нөхцөлийн шаардлагад нийцэж байгааг үйлдвэрлэгч баталгаажуулж байна.

Үйлдвэрлэгч нь материалтай ажиллах технологийг дагаж мөрдөхгүй байх, түүнчлэн эдгээр зааварт заагаагүй зорилго, нөхцөлд ашиглах үед хариуцлага хүлээхгүй. ГОСТ 8.579-2001 стандартын дагуу цэвэр жингийн хазайлт байна. Бүтээгдэхүүнийг бүх төрлийн иргэний барилгад ашиглахыг зөвшөөрсөн ($A_{эфф} < 370$ Бк/кг байх ОХУ-ын "Цацрагийн аюулгүй байдлын стандартууд" НРБ-99/2009, ариун цэврийн дүрэм, журам СанПиН 2.6.1.25.23–09 нийцсэн.

Техник үзүүлэлтүүд

Хуурай хольцын хувьд	
Дүүргэгчийн хамгийн том ширхгийн хэмжээ	2,5 мм
Том хэмжээтэй ширхгийн агууламж	0,5%-иас ихгүй
1 кг хольцод хэрэглэх усны хэмжээ	0,17-0,22 л
Хэрэглэхэд бэлэн хольцын хувьд	
Зуурмаг хольцын амьдрах чадвар 5 минутын дараа 40 минутын дараа	120-150 мм 110 мм багагүй
Ус тогтоох чадвар	95% -иас багагүй
Хатуурсан зуурмагийн хувьд	
28 хоногийн дараа шахалтын бат бэхийн хязгаар	5 МПа-аас багагүй
Зуурмагийн бетонд наалдах бат бэх хүчдэл	0,3 МПа-аас багагүй
Ашиглах үеийн температур	-50°C-аас +60°C хүртэл
Зуурмагийн хүйтэнд тэсвэртэй байдлын марк	F50 багагүй
Хагарал цууралтад тэсвэртэй	өнгөлгөөний шавардлагыг давхаргын дагуу бүхэлд нь хагарал цууралт харагдахгүй байх
Байгалийн радионуклидын цацраг идэвх	370 Бк/кг ихгүй

Логистикийн мэдээлэл

Хувийн бар-код 4607013046740

Нэг багц дахь уутны тоо – 48 ширхэг